



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

**Иргэдтэй хийх уулзалтын хуваарийг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/11 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтанд нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам"-ыг мөрдөж ажиллахыг удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Дүүргийн удирдлагын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3. Иргэдтэй хийх уулзалтын хуваарь шинэчлэн батлагдаж байгаатай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/148 дугаар захирамжийн хавсралтыг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Дэлгэрмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

1160201638

Баянгол дүүргийн Засаг даргын
 2017 оны 03 дүгээр сарын 09-ны өдрийн
 №195 дугаар захирамжийн хавсралт



УДИРДЛАГУУДЫН ИРГЭД ХҮЛЭЭЖ АВАХ ХУВААРЬ

№	Иргэд хүлээн авах удирдлагын нэр, албан тушаал	Иргэд хүлээн авах хугацаа	Холбогдох утасны дугаар	Уулзалтын байр	Уулзалтыг зохион байгуулах албан хаагч
1	Засаг дарга С.Одонтуяа	Баасан гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ /Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн/
2	Засаг даргын орлогч Э.Батбилэг /Эдийн засаг, худалдаа, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан/	Даваа гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ /Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн/
3	Засаг даргын орлогч Г.Нарангэрэл /Эрүүл мэнд нийрмийн бодлогын асуудал хариуцсан/	Лхагва гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ /Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн/
4	Тамгын газрын дарга Д.Дэлгэрмаа	Пүрэв 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ /Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн/